



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 25

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 39 дүгээр зүйл, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тус аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны Улсын хяналтын байцаагч нараас Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл, гомдлыг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Энхбат

-Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд:

Э.Оюунболд


-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Б.Болорзул

-Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

2.Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж, дүгнэлт, санал боловсруулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2018 оны 07 дугаар сарын 06-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Энхбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ө.СУВДАА